


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-17 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **1110** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1110 тохиолдлын 94% /1042/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /68/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/, Дорноговь /2/ ) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 314 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

## ЭПИДЕМИОЛОГИЙН 17 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.04.20 - 04.26)


2025 оны эпидемиологийн 17 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын 44 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 64%-иар буурсан үзүүлэлттэй байна.



### ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ


Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эпидемиологийн 1-17 дугаар долоо хоногт нийт 310 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

<p><b>155</b></p> <p>Эмнэлгийн тусламж авч буцсан</p>	<p><b>155</b></p> <p>Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан</p>	<p><b>0</b></p> <p>Нас барсан</p>	<p>Эрэгтэй <b>46%</b></p>	<p>Эмэгтэй <b>54%</b></p>
---	--	-----------------------------------	---------------------------	---------------------------



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 17 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **11** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 62%-аар, сүүлийн 5 жилийн дунджаас 15%-аар тус тус буурсан байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 17 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	5	5
2	Эмийн хордлого	6	0	6
	<b>Нийт</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>11</b>

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд 34%-ийг эрэгтэй, 66% -ийг эмэгтэй хүмүүс эзэлж байгаа бөгөөд 19-өөс 51 насныхан байна. **Санамсаргүйгээр** өртсөн тохиолдлуудыг шалтгаанаар авч үзвэл белизна, аяга таваг угаагч шингэн зэрэг ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай бүтээгдэхүүн болон бензин, машины үнэртүүлэгч зэрэг машин, техникийн зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хордсон байна.

-оОо-